

ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛ

ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН ХУРАЛДААН – Хуралдааны тойм

ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН ХУРАЛДААНААР ХЭЛЭЛЦСЭН АСУУДЛЫН ХӨТӨЛБӨР № 24 (ТОЙМ)

Хуралдаан 2011 оны 12 дугаар сарын 22-ны өдрийн 14 цаг 45 минутанд эхэлж, 15 цаг 25 минут хүртэл Төрийн албаны зөвлөлийн хуралдааны танхим (Засгийн газрын 11 дүгээр байрны 301 тоот өрөө)-д болж, нийт 00 цаг 40 минут үргэлжлэв.

№	Хэлэлцсэн асуудал	Гарсан шийдвэр
1	2011 оны 12 дугаар сарын 09, 10-ны өдрүүдэд Нийслэл дэх нутгийн захиргааны байгууллагын төрийн жинхэнэ албан тушаалын сул орон тоог нөхөх төрийн жинхэнэ албан тушаалд анх орох иргэдээс авсан төрийн жинхэнэ албаны мэргэшлийн шалгалтын дүн, уг шалгалтанд тэнцсэн иргэдийг төрийн жинхэнэ албанд анх орох иргэний нөөцийн жагсаалтад бүртгэж, бүртгэгдсэн иргэдээс онооны дарааллыг баримтлан өрсөлдсөн албан тушаалд нь нэр дэвшүүлэх тухай	<p>Төрийн албаны тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.3, Төрийн албаны зөвлөлийн 2009 оны 63 дугаар тогтоолоор баталсан “Төрийн жинхэнэ албаны мэргэшлийн шалгалт авах журам”-ын 55 дугаар зүйлийг баримталж, 2011 оны 12 дугаар сарын 09, 10-ны өдрүүдэд Нийслэлд зохион байгуулсан Төрийн албаны мэргэшлийн шалгалтад тэнцсэн иргэдийг төрийн жинхэнэ албан тушаалд анх орох иргэний нөөцийн жагсаалтад бүртгэх тухай Төв комиссын саналыг хэлэлцсэн Төрийн албаны зөвлөлийн 2011 оны 12 дугаар сарын 22-ны өдрийн хуралдааны шийдвэрийг үндэслэн:</p> <p>1.2011 оны 12 дугаар сарын 09, 10-ны өдрүүдэд Нийслэлд зохион байгуулсан төрийн жинхэнэ албаны мэргэшлийн шалгалтад тэнцсэн нэр бүхий 170 иргэнийг “Дэс түшмэлийн ангиллын төрийн жинхэнэ албан тушаалд анх орох иргэний нөөцийн жагсаалт”-д бүртгэснийг 1 дүгээр хавсралтаар батлах,</p> <p>2.Энэхүү тогтоолын нэгдүгээр зүйлд заасан “Дэс түшмэлийн ангиллын төрийн жинхэнэ албан тушаалд анх орох иргэний нөөцийн жагсаалт”-д бүртгэгдсэн иргэдээс хамгийн өндөр оноо авсан нэр бүхий 25 иргэнийг тус тусын өрсөлдсөн албан тушаалд томилуулахаар нэр дэвшүүлж, нэрсийг 2 дугаар хавсралтаар батлах,</p> <p>3.Энэхүү тогтоолын хоёрдугаар зүйлд заасан</p>

		<p>нэр бүхий 26 иргэнийг тухайн албан тушаалд томилуулахыг Нийслэл дэх Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн дарга (Ц.Болдсайхан)-д үүрэг болгох,</p> <p>4.Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн албаны зөвлөлийн гишүүн, Төрийн албаны мэргэшлийн шалгалтын төв комиссын дарга Д.Батбаярт даалгах тухай Монгол Улсын Төрийн албаны зөвлөлийн тогтоол гаргахаар тогтов.</p>
2	<p>2011 оны 12 дугаар сарын 17-ны өдөр Баян-Өлгий, Булган, Говьсүмбэр, Өмнөговь, Төв, Хэнтий аймгуудад тус тус зохион байгуулагдсан нутгийн захиргааны байгууллагын төрийн жинхэнэ албан тушаалын сул орон тоог нөхөх зорилго бүхий төрийн жинхэнэ албаны мэргэшлийн шалгалтын дүн, уг шалгалтанд тэнцсэн иргэдийг төрийн жинхэнэ албанд анх орох иргэний нөөцийн жагсаалтад бүртгэж, бүртгэгдсэн иргэдээс онооны дарааллыг баримтлан өрсөлдсөн албан тушаалд нь нэр дэвшүүлэх тухай</p>	<p>Төрийн албаны тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.3, Төрийн албаны зөвлөлийн 2009 оны 63 дугаар тогтоолоор баталсан “Төрийн жинхэнэ албаны мэргэшлийн шалгалт авах журам”-ын 55 дугаар зүйлийг баримталж, 2011 оны 12 дугаар сарын 17-ны өдөр Баян-Өлгий, Өмнөговь, Төв, Хэнтий, Говьсүмбэр аймагт тус тус зохион байгуулсан Төрийн албаны мэргэшлийн шалгалтад тэнцсэн иргэдийг төрийн жинхэнэ албан тушаалд анх орох иргэний нөөцийн жагсаалтад бүртгэх тухай Төв комиссын саналыг хэлэлцсэн Төрийн албаны зөвлөлийн 2011 оны 12 дугаар сарын 22-ны өдрийн хуралдааны шийдвэрийг үндэслэн:</p> <p>1.2011 оны 12 дугаар сарын 17-ны өдөр Баян-Өлгий, Өмнөговь, Төв, Хэнтий, Говьсүмбэр аймагт тус тус зохион байгуулсан төрийн жинхэнэ албаны мэргэшлийн шалгалтад тэнцсэн нэр бүхий 62 иргэнийг “Дэс түшмэлийн ангиллын төрийн жинхэнэ албан тушаалд анх орох иргэний нөөцийн жагсаалт”-д, нэр бүхий 58 иргэнийг “Туслах түшмэлийн ангиллын төрийн жинхэнэ албан тушаалд анх орох иргэний нөөцийн жагсаалт”-д бүртгэснийг 1-10 дугаар хавсралтаар батлах,</p> <p>2.Энэхүү тогтоолын нэгдүгээр зүйлд заасан “Дэс түшмэлийн ангиллын төрийн жинхэнэ албан тушаалд анх орох иргэний нөөцийн жагсаалт”-д бүртгэгдсэн иргэдээс хамгийн өндөр оноо авсан нэр бүхий 32 иргэнийг, “Туслах түшмэлийн ангиллын төрийн жинхэнэ албан тушаалд анх орох иргэний нөөцийн жагсаалт”-д бүртгэгдсэн иргэдээс хамгийн өндөр оноо авсан нэр бүхий 29 иргэнийг тус тусын өрсөлдсөн албан тушаалд томилуулахаар нэр дэвшүүлж, нэрсийг 11-20</p>

		<p>дугаар хавсралтаар батлах,</p> <p>3.Энэхүү тогтоолын хоёрдугаар зүйлд заасан нэр бүхий 61 иргэнийг тухайн албан тушаалд томилуулахыг Баян-Өлгий, Өмнөговь, Төв, Хэнтий, Говьсүмбэр аймаг дахь Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн даргад үүрэг болгох,</p> <p>4.Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн албаны зөвлөлийн гишүүн, Төрийн албаны мэргэшлийн шалгалтын төв комиссын дарга Д.Батбаярт даалгах тухай Монгол Улсын Төрийн албаны зөвлөлийн тогтоол гаргахаар тогтов.</p>
3	Хүний эрхийн үндэсний комиссын Ажлын албаны даргын албан тушаалд томилогдох удирдах ажилтныг сонгон шалгаруулахаар уг ажлын байрыг нийтэд нээлттэй зарлах тухай	Хүний эрхийн үндэсний комиссын Ажлын албаны даргын албан тушаалд томилогдох удирдах ажилтныг сонгон шалгаруулахаар уг ажлын байрыг нийтэд нээлттэй зарлахаар тогтов.
4	Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Хүүхдийн төлөө газрын Хүүхдийн хөгжил, оролцооны хэлтсийн даргын албан тушаалд томилогдох удирдах ажилтныг сонгон шалгаруулахаар уг ажлын байрыг нийтэд нээлттэй зарлах тухай	Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Хүүхдийн төлөө газрын Хүүхдийн хөгжил, оролцооны хэлтсийн даргын албан тушаалд томилогдох удирдах ажилтныг сонгон шалгаруулахаар уг ажлын байрыг нийтэд нээлттэй зарлахаар тогтов.
5	Говь-Алтай аймаг дахь Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн даргыг томилох тухай	<p>Улсын Их Хурлын 2009 оны 87 дугаар тогтоолоор баталсан “Төрийн албаны зөвлөлийн үйл ажиллагааны дүрэм”-ийн “Гурав”-ын 3.3-т заасныг баримталж, Төрийн албаны зөвлөлийн 2011 оны 12 дугаар сарын 22-ны өдрийн хуралдааны шийдвэрийг үндэслэн:</p> <p>1.Говь-Алтай аймаг дахь Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн даргаар тус аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга Цэрэндашийн Батзоригийг томилох,</p> <p>2.Энэхүү тогтоол гарсантай холбогдуулан Төрийн албаны зөвлөлийн 2010 оны 04 дүгээр сарын 30-ны өдрийн 73 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтын 5-д “...Цэрэнбалжирын Самбуудаш” гэснийг хүчингүй болсонд тооцох,</p> <p>3.Салбар зөвлөлийн ажлыг хууль, тогтоомж, холбогдох дүрэм, журамд чанд нийцүүлэн гүйцэтгэхийг Салбар зөвлөлийн дарга Ц.Батзоригт даалгах тухай Монгол Улсын Төрийн албаны зөвлөлийн тогтоол гаргахаар</p>

		ТОГТОВ.
6	Бусад асуудал: Төрийн албаны зөвлөлийн 2011 онд дэвшүүлсэн зорилтын хэрэгжилт, 2012 онд дэвшүүлэх зорилтын тухай	Төрийн албаны зөвлөлийн 2011 онд дэвшүүлсэн зорилтын хэрэгжилт, 2012 онд дэвшүүлэх зорилтын тухай Монгол Улсын Төрийн албаны зөвлөлийн тогтоол гаргахаар тогтов.
7	Бусад асуудал: Төрийн албаны зөвлөлийн орон тооны бус гишүүд болон Төрийн албаны мэргэшлийн шалгалтын төв комиссын (дарга, нарийн бичгийн даргаас бусад) гишүүдийн хуралдаанд оролцсоны урамшууллын тухай	Төрийн албаны зөвлөлийн орон тооны бус гишүүд болон Төрийн албаны мэргэшлийн шалгалтын төв комиссын (дарга, нарийн бичгийн даргаас бусад) гишүүдийн хуралдаанд оролцсоны урамшууллыг шинэчлэн олгох тухай Төрийн албаны зөвлөлийн тогтоол гаргахаар тогтов.

-----oOo-----